

## ЭРДЭНЭ РЕСУРС 2021 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛЛАА

---

### Хэвлэлийн мэдээ

Халифакс хот, Нова Скошиа муж  
2021.05.17

**Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD; MSE:ERDN) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани")** нь 2021 оны 3 сарын 31-нд дуусгавар болсон нэгдүгээр улирлын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Баян Хөндий Алтны Төслийн ("Баян Хөндий" эсвэл "БХ") хөгжүүлэлтийн мэдээлэл хүргэж байна. SEDAR болон компанийн вебсайт дээр байршуулсан 2021 оны нэгдүгээр улирлын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан ("MD&A" буюу "Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ") нь энэхүү хэвлэлийн мэдээний салшгүй нэг хэсэг болно.

### Онцлох мэдээлэл:

- Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлт
  - Нарийвчилсан загварчлал болон инженерчлэлийн ажлыг эцэслэв.
  - Боловсруулах үйлдвэрээс бусад дэд бүтцийн холбогдох зөвшөөрлийг авав.
  - Хүдэр бутлах циклийн холбогдох гэрээг байгуулав.
  - Төслийн болон үйл ажиллагааны баримт бичгүүд, байгууллагын бүтцийг боловсруулав.
- Канадын Экспорт Хөгжлийн Агентлаг ("EDC")-ийн төслийн санхүүжилтийн нарийвчилсан судалгааны ажлын хүрээнд Зөвлөхүүд төслийн талбай дээр ажиллав.
- Хар Морь талбайд газрын дөт гүнд өндөр агуулга бүхий алтны эрдэсжилтийг илрүүлэв.
  - Алтны эрдэсжилтийг 1.4 км судлын турш үргэлжлүүлэн тодорхойлсон.
  - Алтны өндөр агуулга бүхий бүсийг газрын гадаргаас 10 метрийн гүнд илрүүлэв.
    - Хоорондоо 100 метрийн зайтай хоёр цооногт 5.97 г/т алтны агуулга бүхий 45 метрийн интервал (AAD-58) болон 2.67 г/т алтны агуулга бүхий 35 метрийн интервал (AAD-81) огтолсон.
- Хоёрдугаар улирлын эцэст Хар Морь, Алтан Нар, мөн Улаан тусгай зөвшөөрлийн талбайн зүүн өмнөд хэсэгт томоохон өрөмдлөгийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

## Тодруулга

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Нэгдүгээр улиралд бид Баян Хөндий Алтны Төслийн (“Баян Хөндий” эсвэл “БХ”) хөгжүүлэлт болон Хөндий Алтны Дүүргийн өндөр агуулга бүхий нөөцийг тэлэх гол зорилтуудын хүрээнд үр дүнтэй ажиллалаа.”

“Баян Хөндий Алтны Төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажил болон холбогдох зөвшөөрлүүдийг авах ажил үр дүнтэй явагдаж байгаа бөгөөд төсөл байршдаг Баянхонгор аймагт ажлын байрны чиглэл олгох сургалтыг зохион байгуулсан.” “Канадын Экспорт Хөгжлийн Агентлаг (“EDC”) нь Баян Хөндийн Алтны Төслийн санхүүжилтийн нарийвчилсан судалгааны ажлыг гүйцэтгэж байна.”

“Түүнтэй зэрэгцэн, нэгдүгээр улиралд хийгдсэн өрөмдлөг, хайгуулын хөтөлбөрийн үр дүнд Хар Морь талбайг Баян Хөндий алтны ордын нээлтээс хойш бидний Хөндий Алтны дүүрэгт илрүүлсэн хамгийн чухал эрдэсжсэн бүс гэдгийг баталгаажуулсан.” “Бид эрдэсжилтийг 1.4 км трендийн дагуу үргэлжлүүлэн тодорхойлсон бөгөөд эрдэсжилт нь суналын дагуу болон гүн рүүгээ нээлттэй. Хоёрдугаар улирлын сүүлд Хар Морь, Улаан талбайн анхан шатны өрөмдлөг болон Алтан Нарын урьд нь өрөмдлөг хийгдээгүй өндөр агуулга бүхий бүсийг өргөжүүлэх өрөмдлөгийн хөтөлбөрийн төлөвлөгөөг эцэслэж байна.”

“Компанийн хээрийн ажил, үйл ажиллагаа харьцангуй саадгүй хэрэгжсээр ирсэн боловч Монгол Улсад Ковид-19 цар тахлын тархалт нэмэгдэн, төсөл байршдаг Баянхонгор аймагт халдварын тохиолдлууд бүртгэгдэж эхэлсэн.” “Бид аюулгүй ажлын байр, халдваргүй орчныг бүрдүүлэх зорилгоор боломжит бүх арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ба Монгол Улс дахь Ковид-19 халдварын нөхцөл байдал нь Баян Хөндий алтны төслийн барилгын бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд үзүүлэх нөлөөллийг судалж байна.” хэмээн онцоллоо.

## 2021 оны нэгдүгээр улирлын онцлох үйл явдлууд:

### Хөндий Алтны Төсөл–Эрдэнэ Ресурсийн 100% эзэмшил

- Баян Хөндий Алтны Төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын явц:
  - Уламжлалт нүүрсэнд уусгах технологи (CIP) бүхий боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан загварчлал, инженерчлэлийн ажлыг 2021 оны нэгдүгээр улиралд гүйцэтгэсэн – захиргааны байгууллагын дүгнэлт 2021 оны хоёрдугаар улиралд эхэлнэ.
  - 2021 оны 3-р сард хагас өөрөө нунтаглагч (SAG) тээрэм болон бөмбөлөгт (Ball) тээрэм нийлүүлэх гэрээг CITIC компанитай байгуулсан.
  - Гол боловсруулах үйлдвэрийн бус байгууламжуудын нарийвчилсан зураг төслийг захиргааны байгууллагаар батлуулж, бичиг баримтуудыг эцэслэн бүртгүүлэхээр хүлээгдэж байна.
  - 2021 оны 3-р улиралд бусад байгууламжуудын зөвшөөрлийн өргөдлийг захиргааны байгууллагад мэдүүлэхээр төлөвлөж байна.

- Бүтээн байгуулалт, худалдан авалт, эрүүл ахуй ба аюулгүй ажиллагааны гарын авлага болон үндсэн үүргийн ажлын байрны тодорхойлолтыг барилга угсралтын ажлаас урьдчилж боловсруулсан.
- Орон нутгийн иргэдэд зориулж, Баян Хөндий төслийн кемп дээр ажлын байрны чиглэл олгох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.
  - Хоёр ээлжийн 36 иргэдэд Эрдэнэ Ресурсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчин, олон нийттэй харилцах баг сургалт хийсэн бөгөөд цаашдын сургалтуудад оролцохоор 140 гаруй иргэд бүртгүүлээд байна.
  - Сургалтад төсөл хөгжүүлэлтийн төлөвлөгөө, байгаль орчны менежмент болон төслийн үйл ажиллагаанд орон нутгийн иргэд оролцох боломж зэрэг сэдвүүд багтсан.
  - Ирээдүйн хөтөлбөрүүдийг боловсруулахдаа бид төсөл хэрэгжих хугацаанд орон нутгийн иргэд ажлын байраар хангагдахад шаардлагатай ур чадварыг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэхэд анхааран, дадлага хийх, мэргэжлийн гэрчилгээ олгох хөтөлбөрүүдийг багтаасан.
- Уурхайн хөгжүүлэлтэд шаардлагатай гол зөвшөөрлүүдийг авсан:
  - Таван үндсэн үйлдвэрийн бус дэд бүтцийн холбогдох зөвшөөрлийг авсан.
  - Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас дотоод хөл хөдөлгөөн болон олон нийтийн цуглааныг хязгаарласан учир Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээ гүйцэтгэх хугацааг 2021 оны 9-р сарын 30 хүртэл сунгуулсан.

## Хайгуул

- Хар Морь талбайд газрын дөт гүнд өндөр агуулга бүхий алтны эрдэсжилтийг илрүүлэв.
  - Алтны эрдэжилт 1.4 км трендийн дагуу үргэлжлэн оршиж байна.
  - Хоорондоо 100 метрийн зайтай хоёр цооногоор газрын дөт гүнд хүчтэй исэлдсэн, өндөр агуулга бүхий алтны эрдэсжилтийн бүсийг газрын гадаргаас 10 метрийн гүнээс эхлэн илрүүлэв.
    - AAD-58 – цооногийн 10 метрийн гүнээс эхлэн 5.97 г/т алтны агуулга бүхий 45 метрийн интервал огтолсон нь 82.5 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал багтаасан 27.1 г/т алтны агуулга бүхий 8 метрийн интервал агуулж байна.
    - AAD-81 – цооногт газрын гадаргаас 4 метрээс эхлэн 2.65 г/т алтны агуулга бүхий 35 метрийн интервал огтолсон, үүнд 5.1 г/т алтны агуулга бүхий 12 метр интервал, мөн 14 г/т болон 19 г/т алтны агуулга бүхий 1 метр интервалууд багтана.
  - Газрын дөт гүнээс эхлэх алтны эрдэсжилт бүхий өргөн бүсүүд
    - AAD-61 – AAD-58 цооногоос хойд зүгт 670 метрт байрлах цооногт 10 метрийн гүнээс эхлэн 0.53 г/т алтны агуулга бүхий 130 метрийн интервал огтолсон.

- AAD-66 – AAD-61 цооногоос хойд зүүн зүгт 150 метрт байрлах цооногт 14 метрийн гүнээс эхлэн 1.31 г/т алтны агуулга бүхий 53 метрийн интервал, 112 метрийн гүнээс эхлэн 1.74 г/т алтны агуулга бүхий 20 метрийн интервал огтолсон.
- 220м хүртэлх гүнд нээлттэй
  - AAD-57 – 192 метрээс эхлэн 1.7 г/т алтны агуулга бүхий 30 метрийн интервал огтолсон.
- Эрдэнийн 100% эзэмшил Алтан Нар төслийг багтаасан Хөндий Алтны Дүүргийн хэтийн төлөв бүхий эрдэсжилтийн систем, Хөндий-Улаан геологийн загварчлалын тайллыг хийх техникийн мэргэжилтнүүдийн багтай хамтран ажиллах болсон.
  - Геологи, структур болон геофизикийн загварчлал, спектрийн хувирал, шавар эрдсийн шинжилгээ, петрографийн үр дүнг нэгтгэн 2021 оны хайгуулын хөтөлбөрт багтах өрөмдлөгийн чиглэлүүдийг тодорхойлно.

### Компанийн тухай

- Канадын Экспорт Хөгжлийн Агентлаг (“EDC”)–тай хамтран Баян Хөндий Алтны Төслийн санхүүжилтийн нарийвчилсан судалгааны ажлыг гүйцэтгэж байна:
  - 1-р улиралд төслийн талбай дээр зөвлөхүүд ажилласан бөгөөд судалгааны тайлангийн төслийг хүлээн авсан.
  - Канадын Экспорт Хөгжлийн Агентлагтай зурсан санхүүжилтийн баримт бичиг нь \$55 сая ам.доллар хүртэл зээлийн санхүүжилтийг төвлөрүүлэх зорилт бүхий баримт бичиг бөгөөд нарийвчилсан судалгааг хийж гүйцэтгэснээр эцэслэх нөхцөлтэй.
- 2021 оны 3 дугаар сарын 31-нд дуусгавар болсон гурван сарын сүүлээр компанийн алдагдал \$617,084 кан.доллар байсан нь 2020 оны 3 дугаар сарын 31-ний \$1,041,990 кан.доллартай харьцуулахад буурсан үзүүлэлт байв.
- 2021 оны 3 дугаар сарын 31-нд дуусгавар болсон гурван сард капиталжуулсан зардлыг хамруулсан хайгуулын зардал \$2,523,968 кан.доллар байсан нь 2020 оны 3 дугаар сарын 31-ний \$1,511,929 кан.доллартай харьцуулахад өссөн нь хайгуулын ажлыг эрчимжүүлж, 3,100 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэсэнтэй холбоотой ба өмнөх оны мөн үед өрөмдлөгийн ажил гүйцэтгээгүй. Түүнчлэн, Баян Хөндий төслийн нарийвчилсан ТЭЗҮ, нарийвчилсан инженерчлэл, зураг төсөл боловсруулах зэрэг бүтээн байгуулалтын бэлтгэл ажилтай холбоотой зардлууд өссөн нь тухайн зардал өмнөх оны мөн үеийнхээс нэмэгдэх хүчин зүйл болсон.
- Компанийн захиргаа, удирдлагын зардал нь 2020 оны 3 дугаар сарын 31-нд дуусгавар болсон эхний гурван сарын хугацаанд \$374,074 байсан нь 2021 оны мөн үед \$394,604 болж өссөн байна. Энэ нь зөвлөх болон мэргэжлийн үйлчилгээний төлбөр, захиргааны байгууллагын зохицуулалтын зардал, ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал буурснаас үүдэн хувьцаанд суурилсан

урамшууллын зардал өссөн болон хөрөнгө оруулагчидтай харилцах зардал буурсантай холбоотой.

### **Монгол Улс дахь Ковид-19 нөхцөл байдал**

2020 оны нэгдүгээр сараас эхлэн Монгол Улсын Засгийн газар олон улсад зорчих иргэдийн хөдөлгөөн, бүх шатны хичээл сургалтын үйл ажиллагааг хязгаарлах, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох зэргээр иргэдээ цар тахлаас хамгаалах арга хэмжээг үр дүнтэйгээр хэрэгжүүлсэн. 2020 оны 3-р сараас эхлэн Канад ба бусад улуудын засгийн газрууд дээрхтэй ижил хязгаарлалтуудыг хэрэгжүүлж эхэлсэн. 2020 оны 11 сард Монгол Улсад цар тахал голомтлон тархсанаас үүдэн Монгол Улсын Засгийн газар дотоодын хөл хөдөлгөөн болон бараа материалын тээвэрлэлтэд хязгаарлалт хийсэн. 2021 оны нэгдүгээр улирлын дунд үеэс хязгаарлалтыг сулруулсан боловч бүртгэгдсэн тохиолдлуудын тоо нэмэгдсэний улмаас 2021 оны хоёрдугаар улирлын эхэн үед урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн. Түүнчлэн, 2021 оны 3-р сард Эрдэнэ Ресурсийн төслүүд байрладаг Баянхонгор аймагт Ковид-19 -ийн халдварын анхны тохиолдлыг мэдээлж, аймаг руу ирж очих болон аймаг доторх хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон. Компани Баянхонгор аймаг дахь Ковид-19 тархалтыг хумих үйл ажиллагааг дэмжиж, Аймгийн Онцгой Комисст яаралтай тусламжийн санхүүжилт хүргэж, хувийн хамгаалалтын тоног төхөөрөмжөөр хангаж ажилласан.

Ковид-19 цар тахлын Компанийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл өнөөг хүртэл бага байсан боловч халдварын цар хүрээ тэлсээр байна. Компани нь халдварын нөхцөл байдал Баян Хөндий алтны төслийн барилгын бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд үзүүлэх нөлөөллийг судалж байна. Үүний зэрэгцээ Компани нь бүтээн байгуулалтын бэлтгэл ажлууд болох нарийвчилсан инженерийн болон зураг төсөл боловсруулах, худалдан авалт, Баянхонгор аймгийн засаг захиргааны байгууллагатай орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг байгуулах, Канадын Экспорт Хөгжлийн Агентлагийн төслийн санхүүжилтийн нарийвчилсан судалгаа зэрэг ажлуудыг үргэлжлүүлэн хийж байна. Нэмж дурдахад, Компанийн Монгол хайгуулын баг эрүүл мэнд, аюулгүй үйл ажиллагааны тусгайлсан протокол баталж, хайгуулын хөтөлбөрүүдийг саадгүй үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Канад, Монгол дахь Эрдэнэ Ресурсийн захиргааны ажилтнууд цар тахлын үеэр зайнаас ажиллах зарчмыг баримталж байна.

Засгийн газар хязгаарлалтуудыг сулруулж, вакцинжуулалтыг өргөн хүрээнд гүйцэтгэснээр 2021 оны 2-р улирлын сүүлчээс эхлэн Монголын эдийн засгийг аажмаар нээн, Канад дахь ажилтнууд болон зөвлөхүүд Монголд ирж ажиллах боломжууд нээгдэнэ хэмээн итгэж байна. Эдийн засгийг нээснээр, орон нутгийн иргэдийн үйл ажиллагаа хэвийн байдалд эргэн орох ба ажилчдын аюулгүй байдал болон ажлын байрны сургалт, мөн Компанийн Байгаль Орчны Нарийвчилсан Нөлөөллийн Үнэлгээ ("БОННУ") батлуулах ажлын хүрээнд шаардагдах иргэдийн хурлыг зохион байгуулах зэрэг ажлыг дахин эхлүүлж болно. БОННУ-г батлуулснаар

ирээдүйн тусгай зөвшөөрлүүдийг авах үйл явцыг эрчимжүүлж, барилгын ажлыг эхлүүлэх ач холбогдолтой. Одоогоор 2021 оны 3-р улиралд БОННУ-г батлуулахаар тооцоолж байна.

2021 оны 3-р улиралд БОННУ-г батлуулснаар ажилчдын кэмп, агуулах байгууламж, худаг болон үндсэн замын ажлуудыг 2021 оны хоёрдугаар хагаст эхлүүлнэ гэж төлөвлөж байна. Монгол Улсын өвлийн улирлын нөхцөл байдлыг харгалзан 2022 он хүртэл бетон, төмөр хийцийн томоохон ажил хийгдэхгүй гэж тооцвол 2023 оны эхний хагаст үйлдвэрлэл эхлэх нөхцөл бүрдэхээр байна. Энэ хугацаанд Хар Морь ба Улаан талбайн хайгуулын ажлын үр дүнг дүгнэж, хөгжүүлэлтийн төлөвлөгөөнд гарч болзошгүй өөрчлөлтүүдийг тодорхойлно.

Ковид-19 цар тахал Компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх болон Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтийн хуваарийн мэдээллийг цаг тухайд мэдээлэх болно.

### Компанийн тухай

Компанийн тухай Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өндөр агуулга бүхий алт, алт суурь металлын хэтийн төлөв бүхий талбайнуудыг нээн илрүүлснээс хөгжүүлэлт хийх боломжтой хэмээн Баян Хөндий, Алтан Нар ордуудыг тодорхойлсон.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com) -оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

### Мэргэшсэн этгээд (геологч)

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geо, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно.

## Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал  
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: [info@erdene.com](mailto:info@erdene.com)

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>